




Монголын үйлдвэрлэлийн хөгжлийн төлөө



BPN Монгол



BPN Монгол салбарын өнөөдөр ба ирээдүй



BPN Монгол
салбарын захирал:
Рене Лүхсингер

Бизнес эрхлэгчидтэйгээ санал бодлоо солилцон, тэдний бүтээгдэхүүн, хэрэглэгчид болон өөрийн компанийхаа төлөөх урам зоригийг мэдрэх нь миний хувьд үргэлж таатай байдаг. Тэднийг амжилтад хүргэх нэгэн хөдөлгүүр бол урам зориг бүхий бүтээлч байдал гэж би боддог.

BPN Монгол салбарын баг хамт олон 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр хөтөлбөрийн оролцогчдынхоо амжилтыг гол зорилгоо болгон түүнийхээ төлөө тууштай ажиллаж байна. Энэхүү зорилго маань бидний санал болгодог бүхий л сургалт, зөвлөх үйлчилгээ болон зааварчилгаа сургалтуудын хэмжүүр болдог. Түүнчлэн бид үнэ цэнэ бүхий мэдлэг, үнэт зүйлсийг түгээгээд зогсохгүй хөтөлбөрийн оролцогчидынхоо урам зориг, эрч хүч, итгэл найдварыг нь асааж өгдөг. Учир нь бизнес бол үргэлж ялахын төлөө бус, харин хэзээ ч бууж өгөхгүй байхын төлөөх тэмцэл юм.

„Үргэлж ялдаг хүн хамгийн хүчирхэг хүн биш, харин хэзээ ч бууж өгдөггүй хүн хамгийн хүчирхэг байдаг.“

BPN өгөгдсөн хугацаанд хэрэгжээд дуусдаг төслийн хэлбэрээр бус урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах хөтөлбөрийн хүрээнд ажилладаг бөгөөд бидний үүд хаалга бизнес эрхлэгчдэд хувь хүнийх нь хувьд ч, бизнес эрхлэгчийнх нь хувьд ч хэзээд нээлттэй байдаг. Бид бизнес эрхлэгчдийг хөтөлбөрт хамрагдаж буй хугацаагаар үл хязгаарлан дэмжиж, сургалт зөвлөгөөгөө санал болгодог. Чухам үүний тулд бид бизнес эрхлэгчдийн нийгэмлэгээ байгуулсан бөгөөд бусад бизнес эрхлэгчидтэйгээ санал солилцох маш үр дүнтэй платформ юм.

2024 оны онцлох үйл явдал бол Швейцарын бизнес аялал байлаа. Бид аяллынхаа хүрээнд Швейцар улсын шилдэг компаниудаар зочлон гайхалтай туршлага солилцон аяны богц дүүрэн ирсэн.



Үүнээс гадна бид Дархан хотын жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулан анх удаа BPN-ийг танилцуулах арга хэмжээг зохион байгуулж “Борлуулалтыг хэрхэн амжилттай хийх вэ?” сэдэвт зааварчилгаа сургалтыг зохион байгуулсан. Ингэхдээ бид Дарханд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэгчдийн үйлдвэртэй танилцаж цаашдын хамтын үйл ажиллагааны талаар ярилцлаа.

Ирэх онд BPN газар зүйн байршлын хувьд хүрээгээ тэлж Дархан болон Эрдэнэт хотуудын жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, сэдэлжүүлж ажиллахаар төлөвлөж байна.

Гэхдээ бид зөвхөн бизнесийн удирдлагын түвшинд чадавхжуулаад зогсохгүй, урт хугацааны, тогтвортой стратеги хөгжүүлэхэд дэмжих алсын хараатайгаар ажиллаж байна. Амжилттай компаниуд бизнесийн өсөлт үзүүлэхээс гадна хямралыг даван туулах бат бөх суурийг бий болгосон байдаг. Үүнд үнэ цэнийн тодорхой чиг баримжаа, эрсдэлийг ухамсартайгаар хүлээж авах, тасралтгүй суралцах хандлага орно.

BPN зөвхөн мэдлэгийг санал болгодог төдийгүй дотоод болон олон улсын түвшний харилцаа холбоог санал болгодог.

Бидний үүрэг бол бизнес эрхлэгчдийг томоор сэтгэж, том зургаар харахад зоригжуулах билээ. Инновац жижиг зүйлээс эхэлдэг - заримдаа шинэ зүйлийг туршиж үзэх сэдлийг өдөөхүйц санаа байхад л хангалттай байдаг. Бид яг үүнд л төвлөрч ажиллаж байна. Танд урам зориг өгч, хамтдаа байж, түлхэц өгч, алсын хараагаа бодит болгоход туслахыг хүсэж байна.

Байнга хувьсан өөрчлөгдөж байдаг ертөнцөд дасан зохицох чадвар нь амжилтад хүрэх түлхүүр юм. Өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөөд зогсохгүй, түүнийг идэвхтэйгээр ашиглаж чаддаг бизнес эрхлэгчид маргаашийн эдийн засгийг бүрдүүлэгч хүмүүс юм. Монголын ирээдүйг цогцлоохын төлөө хамтдаа зүтгэцгээе.

Хүндэтгэсэн,

Рене Лүхсингер



**Эрхэм хүндэт хамт олон,
Эрхэм бизнес эрхлэгчид ээ,**

Вилли Хелблинг
Гүйцэтгэх захирал
BPN Сан

Оны төгсгөлд түр завсарлаад, бидэнд үзүүлсэн итгэл зүтгэл, хамтын ажиллагаанд талархал илэрхийлье! 2024 он сорилт бэрхшээлүүдээр дүүрэн, мөн үнэ цэнтэй уулзалтууд, ахиц дэвшлээр баян жил байсан бөгөөд энэ хугацаанд бид хамтдаа байж чадсан.

2024 онд BPN үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Бүгд Найрамдах Уганда Улсад шинэ салбараа нээхээр ажиллаж байна. Ингэснээр дэлхийн 6 улсын ЖДБЭрхлэгчдийг дэмжих, чадавхжуулах боломж бүрдэж буй баярт үйл явдал тохиож байна.

Мартин Буберийн "Чамгүйгээр би үгүй" гэсэн үг нь бидний хувьд эв нэгдлийн жинхэнэ утгыг илэрхийлдэг. Бид багаараа, хамтдаа илүү хүчирхэг бөгөөд аливаа амжилт нь зөвхөн бидний хичээл зүтгэлээр бус, бусадтай бий болгосон харилцаа холбоо болон хамтран ажиллаж буй хамтын ажиллагаагаар бий болдог гэдгийг мэдэрсэн. Нийгэм, эдийн засаг урагшилж хөгжихөд та бүгд бүгдээрээ өөрсдийн хувь нэмэрээ оруулсан. Ялангуяа өөрийн гэсэн өвөрмөц соёл, хөгжлийн онцлогтой Монгол орны хувьд хамтдаа байж, бие биеэ дэмжих нь онцгой чухал. Та бүхэн бүгдээрээ улс орныхоо эдийн засгийг бэхжүүлэх, ажлын байр бий болгох, инновацыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Бид энэхүү үйл явцын нэг хэсэг болж, та бүхний аялалд хамт байгаадаа баяртай байна.

Ирэх онд хамтдаа зүтгэж илүү давуу талыг бий болгож, урт хугацааны амжилтад хүрнэ гэсэн итгэл, хүндэтгэл, урам зоригтойгоор мөр зэрэгцэн урагшилья.

Бид тантай хамт шинэ амжилтад хүрч, ирээдүйг хамтдаа бүтээхийг тэсэн ядан хүлээж байна.

Шинэ оны мэнд хүргэж, хамгийн сайн сайхныг хүсэн ерөөе.

Вилли Хелблинг
Гүйцэтгэх захирал
BPN Сан



Оны онцлох үйл явдал

Улиран одож буй он бидэнд арвин их туршлага, мэдлэг болон алдаанаасаа суралцах боломжуудыг олгосон амжилт бүтээлээр дүүрэн он байлаа.

2024 оны BPN-ийн “Highlight” бол эрхэм бизнес эрхлэгчид, BPN-ийн хөтөлбөрийн оролцогчдоо болон тэдний дээд шатны менежерүүдэд “Management Training” хэмээх 2 модуль сургалт байсныг онцлоход таатай байна.

Өнөөгийн эрчимтэй өөрчлөгдөж буй нийгэм, эдийн засгийн орчинд байгууллагын удирдлагууд аливаа өөрчлөлтөд бэлэн байж байгууллага дотроо ажилтнууддаа гадагшаа хэрэглэгч нартаа мэдээллийн урсгалыг маш тодорхой болгохыг зайлшгүй шаардаж байгаа билээ. Тиймээс ч өнөөгийн нөхцөл байдалд удирдлагууд урт хугацааны шийдвэр гаргах үнэхээр хүндрэлтэй болоод байна.

Мөн байгууллага болгон өөрийн гэсэн соёлтой байдгийг бид мэддэг ч тэр соёлыг хэрхэн яаж, хэн бий болгодгийг өөрсдөө ч анзаардаггүй. Байгууллага дотроо тоглоомын дүрмийг ойлгомжтой энгийнээр зохиож түүнд өөрөө ч мэдэлгүйгээр дасан зохицон уусан ордог. Бидний хувьд нийгмийн тогтолцоо солигдоод даруй 30 гаруй жил өнгөрсөн ч ардчилсан эдийн засгийн тогтолцоонд хараахан бүрэн шилжиж чадаагүйг байгууллагын соёл нь харуулж байдаг. Тиймээс ч өнөөдөр удирдлагууд маань компани дотроо соёлыг өөрөө үлгэрлэн түгээж түүгээр дамжин байгууллагын амжилт, өсөлт тодорхойлогдож буйг мэдэрч эхэлж байна. Байгууллага дотроо олон соёлыг бий болгож ажиллах хэдий ч бидний өөрсдөө ч мэдэлгүйгээр бий болгож байдаг “Алдаа” -ны соёл байдаг. Бид амжилтын төлөө тэмүүлэн ажиллаж, ажлын аль ч үе шатад ямарваа нэгэн алдаа гарсан тохиолдолд хэн нэгнийг шууд буруутгаж ХЭН гаргасан бэ гэхээс илүүтэйгээр ЯАГААД алдаа гарах болсон шалтгааныг нь эрэлхийлж цаашид энэхүү алдаанаасаа хэрхэн суралцах вэ гэсэн эерэг дадалд суралцах талаар бид “Management Training”-рээ ярьдаг. Ингэснээр хөтөлбөрийн оролцогчид, захирлуудаа сэдэлжүүлж Швейцар экспертийн туршлагаас хуваалцаж байгаа нь энэ оны “Highlight” болж бизнес эрхлэгчдийн сонирхлыг маш их татаж байна.

“Алдааг сурах боломж болгон ашиглах”

Алдааны эерэг соёл нь ажилтнуудад эерэг таатай мэдрэмж төрүүлж ажлаа амжилттай сайн хийх боломж олгохоос гадна удирдлагуудад ч байгууллагаа амжилттай, бүтээмжтэй удирдах нэгэн үндэс болдог гэдгийг бид ойлгож эхлээд байна.



BPN-ийн
хөтөлбөрийн
удирдагч,
бизнес көүч
О. Эрдэнэсүрэн



Бизнес зөвлөгөө болон удирдлагын көүчинг үйлчилгээ

1992 онд нэгэн бүсгүй хүсэл тэмүүлээ даган гэртээ нэг сүлжмэлийн машинтайгаар нөхрийн хамт өнөөдрийн бизнесийн үндэс сууриа тавьж байжээ. Түүний бүтээгдэхүүнийг авахаар эргэн ирэх хэрэглэгчид, үйлчлүүлэгчид олшрохын хэрээр тэр монгол ноолуурыг хилийн чанадад хүргэх арга замыг эрэлхийлэхээр шийдсэн ба энэ үйлдэл нь хамгийн зоригтой бөгөөд зөв шийдвэр байсан юм. Түүнийг Баярмаа гэдэг бөгөөд 17 жил зүтгэсний эцэст 2009 онд албан ёсоор "Мөнх Бумууд" ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Өнгөрсөн хугацаанд 70 ажилтантай болтлоо өргөжиж чадсан энэ хамт олон Монголын олон зуун жилийн түүхтэй өв соёлоороо бахархаж, нүүдэлчин ахуйг үргэлжлүүлж буй малчдын гар дээрээс түүхий эдээ бэлтгэн авч, урт хугацаанд тогтвортой, байгаль орчинд ээлтэй, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнийг бахархалтайгаар үйлдвэрлэж байна. Тэд 100% дээд зэргийн чанартай ноолуур, сарлагийн хөөврөөр хийсэн эмэгтэй, эрэгтэй хувцас, аксессуар, гэр ахуйн сүлжмэл бүтээгдэхүүнүүдээр мэргэшсэн. Өнөөдөр тус компани Ази, Европ, Хойд Америкийн нийт 18 орон руу бүтээгдэхүүнүүдээ экспорт хийж байна.

Энэхүү гэр бүлийн компанийг үүсгэн байгуулагч Ц.Баярмаатай хийсэн ярилцлагыг та бүхэнд хүргэж байна.

Танай компанийн ойрын 5 жилийн алсын хараа юу вэ?

Бидний ойрын 5 жилийн алсын хараа бол MUNKH Cashmere-ийн чанарыг дэлхийн зах зээлд таниулж, тогтвортой үйлдвэрлэлийг бэхжүүлэх болон өөрийн брэндийн нэр хүндийг олон улсад баталгаажуулах юм. Үүний тулд бүтээгдэхүүний чанар, инновац, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн арга барилыг цогцоор нь хөгжүүлнэ.

Энэхүү алсын хараандаа хүрэхэд тань тулгарч буй гол сорилтууд юу байна вэ?

Гадаад зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлдэг бидний хувьд дараах сорилтууд тулгардаг:

- Олон улсын зах зээлд өрсөлдөхүйц маркетинг, брэндийн танигдалт
- Нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдал
- Санхүүжилт болон хөрөнгө оруулалтын хүрэлцээ
- Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, түүний хэлбэлзэл
- Үйлдвэрлэлд технологи, инноваци нэвтрүүлэх шаардлага.



БPN-ийн
бизнес көүч:
С.Цэндсүрэн



Эдгээр сорилтуудаа шийдвэрлэхэд та бүхэн BPN-ийн зүгээс дэмжлэг, чиглүүлэг авсан уу?

Тийм, BPN-ийн зүгээс бидэнд чиглүүлэг, зөвлөгөө өгч байгаа нь сорилтуудыг тодорхойлж, урт хугацааны шийдлүүдийг олоход ихээхэн тусалж байна.

Өнгөрсөн хугацаанд та бүхэн BPN-ээс ямар сэдвүүдийн хүрээнд бизнес зөвлөгөө, көучинг авсан бэ?

Бид бизнесийн удирдлага, хамт олноо удирдах, олон улсын зах зээлд нэвтрэх стратеги, санхүүгийн менежмент зэрэг сэдвүүдийн хүрээнд удирдлагын багаараа зөвлөгөө, көучинг авсан.

BPN-ийн зөвлөгөө, көучингийн онцлог, давуу тал нь юу байсан бэ? Та өөрийн сэтгэгдлээ хуваалцана уу?

BPN-ийн зөвлөгөө, көучингийн онцлог нь онол, практик хослуулсан байдал, бизнесийн онцлогт тохирсон шийдлүүдийг гаргаж өгдөг явдал юм. Тэд бидний бизнесийн нөхцөл байдалд суурилж, тодорхой алхмуудтай, хэмжиж болохуйц үр дүн бүхий төлөвлөгөө гаргахад дэмжлэг үзүүлсэн. Мөн багийн удирдлагын көучинг болон стратегийн төлөвлөлтийн хувьд хамгийн их үр дүнтэй байсан.

Бидний хувьд BPN-ийн зөвлөхүүдтэй хамтран ажилласнаар компанийнхаа урт хугацааны зорилгоо илүү тодорхой болгож, зорилтууддаа системтэй хүрэх арга замаа олсон гэж боддог.



ВРN-ийн Бизнес Академи

Алсын хараа, зорилгодоо хүрэхийн тулд хамтдаа нэгэн зүгт харж, хамтдаа нэг зүгт чиглэн алхах нь байгууллагын амжилтын түлхүүр юм. Энэ ч утгаараа бид бүхэн байгууллагын сургалтаа санал болгодог билээ.

Энэ онд бид удирдлагын багт зориулсан 2 модуль бүхий „Management Training“ сургалтаа хөтөлбөрийн оролцогчид болох Монтэ Роза сургууль, Чиглэл ХХК, Натуршутц Монгол ХХК болон Ариг Интернэшнл ХХК-уудад зохион байгууллаа. Сургалтын агуулгаас товч дурдвал:

Модуль 1: Байгууллагаа ойлгох нь (бүтэц, соёл), манлайлал гэж юу вэ?, манлайллын 5 үндсэн үүрэг, харилцаа ба асуудлыг шийдвэрлэх аргачлал г.м.

Модуль 2: Мотиваци/Урам зоригжуулах нь, ажилтнуудаа удирдах, чиглүүлэх болон менторлох, байгууллагын соёл-өөрчлөлт-хэвшүүлэлт, удирдлагын оновчтой арга барил г.м.

Модуль 1 сургалтаас олж авсан мэдлэгээ байгууллага дээрээ хэрэгжүүлэхэд хугацаа өгч сайжруулалт болон үр дүн дээр нь тулгуурлан дараагийн модуль сургалтаа санал болгодгоороо онцлог.

ХААН Банк болон ВРN-ийн хамтарсан “Хөгжлийн хөтөлбөр-V” нь бизнес эрхлэгчдийг удирдлагын шийдвэр гаргах төвшинд чадавхжуулах, өөрийн бизнесийн дүр төрхийг хүчирхэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд 2024.09.10-2024.10.08-ны өдрүүдэд нийт таван долоо хоногийн туршид хөтөлбөрийн агуулгын дагуу зохион байгуулагдлаа. Хөтөлбөрийн хугацаанд бизнесийн удирдлагын сургалтууд, Швейцар болон Монгол экспертүүдийн удирдлагын көүчинг, зөвлөх үйлчилгээг санал болгон ажилласан бөгөөд компанийн болон өөрийн бизнесийн үйл ажиллагааны хамгийн чухал цэгийг тодорхойлох, үнэлэх зорилготой көүчингийн шинэ арга барилыг ашигласан нь өвөрмөц байлаа.



Цаг заваа зориулан, идэвхтэй оролцсон бизнес эрхлэгчдэдээ талархан цаашдын ажил үйлсэд нь амжилт хүсье.

Ирж буй 2025 онд бид эх орныхоо хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж буй эрхэм баялаг бүтээгч та бүхэнтэйгээ Швейцар болон Монгол экспертүүдийн сургалтуудаараа дахин уулзахдаа баяртай байна. Монголын үйлдвэрлэлийн хөгжлийн төлөө хамтдаа!



ВРN-ийн
сонгон шалгаруулалт
хариуцсан
зохицуулагч:
Ц.Дуламрагчаа



Гарч буй 2024 онд BPN Бизнес Академийн зүгээс төлөвлөгдсөн сургалтууд маань амжилттай зохион байгуулагдаж дууслаа. Бид үндсэн 4 сургалтаасаа гадна “Хэлэлцээрийг амжилттай хийх нь”, “Борлуулалтын өвөрмөц саналыг тодорхойлох нь” (USP), “Цагийн менежмент” мөн Швейцар улсын хуулийн салбарын эксперт Штефан Хоферийн удирдан явуулсан “Easy Contract & Successful Negotiation”, “Санхүүгийн хөрвөх чадвар” зэрэг сэдэвт сургалтуудаар амжилт дүүрэн энэ оноо үдэж байна.



BPN-ийн сургалт хариуцсан ажилтан:
Э.Хажидмаа



Мөн BPN-ийн хөтөлбөрийг сонирхогч бизнес эрхлэгчдэдээ зориулан “Бизнес төлөвлөгөө”, “Үр ашгийн тооцоо” зааварчилгаа сургалтуудаа 10 удаа зохион байгууллаа.

Ирэх оны сургалтын төлөвлөгөөнд “Хэлцэл болон борлуулалтыг амжилттай хийх нь”, “Contract Readiness & Export Readiness” мөн удаан хүлээгдсэн эрэлт ихтэй байгаа “Зөрчлийн менежмент” сургалт маань орсноос гадна Швейцар эксперт Фрида Вехслерийн “Fundraising” сэдэвт шинэ сургалт багтсан байгаа.

Эрхэм бизнес эрхлэгч хөтөлбөрийн оролцогч, нийгэмлэгийн гишүүд, хамтран ажиллагч байгууллагууд та бүхэнтэйгээ ирэх ондоо итгэл, амжилтаар дүүрэн эргэн уулзахдаа таатай байх болно.

Бизнес эрхлэгчдийн нийгэмлэг

Бизнес эрхлэгчдийн нийгэмлэг нь үр дүн өндөртэй, амжилттай нэгэн жилийг гишүүдийн хамтаар үдэж байна. Бид нийгэмлэгийн зорилгын хүрээнд 2024 онд дараах ажлуудыг зохион байгуулж ажиллаа.

- Бизнес эрхлэгчид өдөр тутамдаа хэлцэл хийх зайлшгүй шаардлагатай тулгарч байдаг бөгөөд бид энэ сэдвээр эхний уулзалтаа хийсэн нь гишүүн бизнес эрхлэгчид өөрсдийн туршлагаа ярилцах, бие биеэсээ суралцах боломжийг олгосон уулзалт болсон.
- Түүнчлэн бизнесийн туршлага хуваалцах зорилгоор бид BPN-ийн хөтөлбөрийн оролцогч Хүүгийн гутал ХХК-ийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлтэй танилцлаа. Тус компани 1994 оноос хойш тасралтгүй гутлын үйлдвэрлэл хийж буй үндэсний үйлдвэрлэгч бөгөөд ерөнхий захирал Г.Алтанхуяг нь бизнесээ амжилттай удирдаж байгаа 2 дахь үеийн бизнес эрхлэгч юм.

BPN-ийн
бизнес көүч:
Х.Ундармаа





- BPN-ийн нийгэмлэгийн давуу тал нь гишүүд гадаад болон дотоодын бизнесийн туршлага судлах байдаг бөгөөд бид Швейцар Улсад бизнес аяллыг 2024 онд 7 хоногийн хугацаатайгаар 11 бизнес эрхлэгчийн хамтаар амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн аяллаар Швейцар Улсын нүүр царай болсон, дэлхийд бүтээгдэхүүний чанараараа тэргүүлэгч компаниудаар зочилж, үйлдвэрлэл үйл ажиллагаатай нь танилцсан юм. Үүнээс дурдвал: эрүүл мэндийн чихэр болон цай үйлдвэрлэгч Ricola ХК, халаасны хутга үйлдвэрлэгч Victorinox ХК, талх нарийн боов үйлдвэрлэгч Reinhart ХК, Lokales Wasser ХК, цахилгааны холболтын эд анги үйлдвэрлэгч Staübli Electrical Connectors ХК, Sauber Motorsport ХК буюу Формула-1, олон улсын уралдааны машин үйлдвэрлэгч, Швейцарын моторспортын инженерийн компаниуд байлаа.
- 2024 оны жилийн эцсийн уулзалт болох Networking Event-ээрээ бид өнгөрсөн жилээ дүгнэн, ирэх жилийн ажлаа хэлэлцэн, нэгэн үдшийг хамтдаа дурсамж дүүрэн өнгөрүүлээ.

BPN-ийн бизнес эрхлэгчдийн нийгэмлэг нь та бүхэнд Networking хийх, бизнесийн мэдээлэл хуваалцах болон олон улсын болон дотоодын туршлага судлах зэрэг үйл ажиллагаануудыг санал болгон ажиллаж байгаа бөгөөд та бүхэн гишүүнчлэлийн дэлгэрэнгүй мэдээллийг бидэнтэй холбогдож аваарай.

2025 оны төлөвлөгөө



Open Day Event



Үйлдвэр, үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох уулзалт



Швейцарын бизнес аялал



Networking Event

ВРN-ийн хөтөлбөрийн оролцогч Магна ББСБ-ын үүсгэн байгуулагч Л.Отгонбаяртай хамтран хэрэгжүүлж буй төсөл болон бусад хөтөлбөрийн тухай ярилцлаа.

1. Та өөрийгөө болон компаниа товч танилцуулна уу?

Миний бие Магна ББСБ-ыг үүсгэн байгуулагаад одоо 10 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Гэр хорооллын иргэд, бичил бизнес эрхлэгчдэд бодит дэм болох, зах зээл дээр гэр хорооллын иргэдийн зээлийн хүүг хамгийн бага түвшинд бууруулах, зардалгүй зээл олгох, бусдыг хүндлэх, нийт харилцагчдаа санхүүгийн зөв дадалд уриалах, олгосон зээл нь иргэдийн амьдрал ахуй дээшлэхэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа өргөжихөд бодит дэмжлэг болох эрхэм зорилготой. Одоо Улаанбаатар хотын 6-н дүүргийн иргэд, бизнес эрхлэгч нарт зээл санхүү, хуримтлалын мэргэшсэн үйлчилгээ үзүүлж байна. Магна ББСБ нь Монголын хамгийн анхны шимтгэл зардалгүй зээл олгосон анхдагч байгууллага.


2. Танай компанийн ойрын 3 жилийн алсын хараа юу вэ?

Бидний үнэт зүйл бол харилцагчдад ээлтэй байх. Бидний алсын хараа дэлхийд тэргүүлэгч санхүүгийн байгууллага болох. Дэлхий дахинаа ногоон зээл, ногоон санхүүжилтээр дамжуулж байгаль дэлхийгээ хамгаалах чиг хандлагад бид суралцаж, ингэснээр олон улсаас ногоон санхүүжилт татаж хэрэглэгчдэдээ олгох зорилго тавин ажиллана. Технологийн хурдтай цаг үетэй хөл нийлүүлэн алхаж, MAGNA.MN APP дээрээ төвлөрч харилцагчийн цагийг хэмнэх, харилцагчдад илүү ээлтэй санхүүжилт олгох дээр төвлөрнө. Бид 2023 онд Мэдээллийн аюулгүй байдлын ISO стандарт нэвтрүүлж, 2024 онд 2 дахь жилдээ энэ стандартаа хянан баталгаажуулсан. Бидний хөгжил дэлхийд чиглэснээр харилцагчид бага хүүтэй санхүүжилт авах боломж нээгдэх болно.

Өнөөдөр манай байгууллага бичил зээл дээр төвлөрөхөөс гадна бизнесийн зээл олгож байна. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, бизнес эрхлэгч нарт санхүүгийн боломж олгох, хамт хөгжих нь бидний туйлын зорилго байх болно. Мөн Магна ББСБ иргэдээс хуримтлал татан төвлөрүүлж үйл ажиллагаа явуулдаг гэдгийг дурдах хэрэгтэй. Манайх хуримтлал нээсэн иргэдэд уян хатан нөхцөл тавьдаг талаараа бусдаас давуу талтай.

3. ВРN байгууллагатай хэзээнээс хамтарч ажиллаж байгаа вэ?

2019 оноос ВРN Mongolia байгууллагын санхүүгийн удирдлага, төслийн удирдлага бизнесийн удирдлагын бүх сургалтад суусан нь миний амьдралд чухал хөгжлийг авч ирсэн. Миний хувьд Бизнесийн удирдлагын талаар анх удаа шинжлэх ухаанчаар суралцсан байгууллага бол ВРN Mongolia. ВРN Mongolia-ын сургалтаар баг хамт олонтойгоо ажил үйлчилгээгээ жижиг жижиг төслүүдэд хувааж, ажлын эхлэх болон дуусах хугацааг тавьж, үр дүнгээ нягтлах аргачлалд сурсан нь манай байгууллагын ажлыг системтэй болгосон. Энэ арга аргачлалд сургасан Швейцар, Монгол зөвлөх багш нартаа үргэлж талархаж явдаг.



4. Хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй, төсөл хөтөлбөрийн тухай?

2019-2022 оны хугацаанд бид BPN байгууллагын бизнесийн удирдлагын бүхий л сургалтад цар тахлын үед ч онлайнаар баг хамт олонтойгоо суралцсаар байсандаа баярладаг. 2023 оноос эхлэн BPN Mongolia, Магна ББСБ-н хамтран ажиллах гэрээний дагуу BPN Mongolia-ын хөтөлбөрийн оролцогч жижиг дунд бизнес эрхлэгч нарт эргэлтийн хөрөнгийн болон тоног төхөөрөмжийн хөнгөлөлтэй зээл олгож байна. Энэхүү хамтын ажиллагаа хөтөлбөрийн оролцогч бизнес эрхлэгч нарт маш чухал дэмжлэг болж байгаа гэдэгт итгэлтэй байна. Цаашид олон жилийн турш нэр төртэй хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр тул бид энэхүү зээлийн хөтөлбөрийг нягт нямбай, нэр төртэй гүйцэтгэх зорилго тавьж байна. Зарим оролцогчид танайх чинь банкнаас бага хүүтэй зээл олгодог юм уу гэж баярлаж гайхаж хүлээн авсан. Хөтөлбөрийн оролцогч нарт олгож буй зээлийн сарын хүү 1,5 хувь байгаа.

5. BPN-ийн нийгэмлэгээс зохион байгуулдаг Швейцарын бизнес аялалд хамрагдсан тухай сэтгэгдлээ хуваалцана уу?

2022, 2024 онуудад Швейцар улсад бизнес аяллаар явж байсан. Өмнө нь Швейцар улсад хэд хэдэн удаа аялж байгалийн сайхныг мэдэрч явсан бол бизнес аяллаар явснаар Made in Swiss яагаад дэлхийд чанараараа тэргүүлдгийг ойлгосон. Дэлхийд тэргүүлэгч олон компанийн хүний нөөцийн бодлого түүнчлэн үйлдвэрлэлийн шат дамжлага зэрэг олон зүйлээс суралцсан. Бизнесийн хамгийн чухал нь бусдын асуудлыг шийдсэн чанартай бүтээгдэхүүн болон үйлчилгээтэй байх ёстой. Сайн бүтээгдэхүүн үйлчилгээ хамгийн чухлаас гадна олон зүйлийг цогцоор нь хийх ёстойг аялал бүрээсээ ойлгож, харж авсан.

6. Бизнес аялаас олж харсан, туршлага судалсан мэдлэгээ компани дээрээ хэрэгжүүлэх боломж хэр байна вэ?

Үзэж харсан зүйлээ алхам алхмаар хэрэгжүүлээд явна. Хүний нөөцийн бодлого, ажилчдын цалин хөлс урамшуулал маш тодорхой байх ёстой. Жилд 53 долоо хоног байдагтай уялдуулж ажлаа төлөвлөж байна. Өөрийн авч хэрэгжүүлсэн ажлын талаар дахин дэлгэрэнгүй ярилцахдаа баяртай байх болно.



ВРН-ийн баг хамт олон



ВРН-ийн сургалтуудын эрхийн бичиг шинээр гарлаа.
Эрхийн бичгийг худалдан авснаар таны сургалтын суудал түрүүлж баталгаажна.



ВРН-ийн 2024 оны онцлох бизнес эрхлэгч

ВРН-ийн хөтөлбөрийн оролцогч “Хөх Суу” ХХК-ийн захирал **Ц.Алтанчимэг** байгалийн цэвэр түүхий эд болох зэрлэг аньс, нэрс жимсээр өтгөрүүлсэн шүүс, цай үйлдвэрлэж хэрэглэгчдэд санал болгож байсан бол 2024 онд шинээр жимсний чанамал үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байна.

Бүтээгдэхүүнүүдэд нэмэлт тогтворжуулагч, амт үнэр оруулагч бодис ороогүй байгалийн цэвэр түүхий эдээр үйлдвэрлэдэгээрээ онцлог.



Хөтөлбөрийн оролцогчдын сэтгэгдэл



ДОДО дент ХХК-ийн захирал

З.Энхцэцэг

2023 оноос хойш BPN-ийн сургалтуудад хамрагдаж эхэлсэн.

Сургалт бүрээс шинэ санаа, мэргэжлийн түвшний мэдээлэл авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Зарим сургалтад 2 дахь удаагаа сууж байгаа ч сургалт бүрийг өөр өөр өнцгөөс харж тусган авч байна.

Хөтөлбөрийн оролцогч болж бизнесийн ахисан түвшинд шилжиж байгаадаа маш их баяртай байна.

BPN-ийн хамт олондоо ажлын өндөр амжилт хүсье.

Та хэддээ маш их баярлалаа.



Management Training сургалт

Уг сургалтад дунд болон түүнээс дээш шатны менежерүүд хамрагдсан бөгөөд удирдлагын нөлөөлөл, манлайлал, гүйцэтгэл сайтай багийг бүрдүүлэх, хувь хүний зан төлөв, сэтгэл зүйд тулгуурлан удирдах арга барилд суралцсан.

Байгууллагын хамгийн гол хүчин зүйл хүний нөөцийг удирдах, ажилтаны зан төлөвд тохирох ажлуудыг санал болгох чадвар, тухайн ажлыг хийж гүйцэтгэх боломжоор хангаж ажиллах нь удирдагч хүнд байх нэн тэргүүний чадвар гэдгийг энэхүү сургалтаар маш гүнзгийрүүлж ойлгож авлаа. Ажилтнуудтайгаа харьцах, чадварлаг баг хамт олныг бүрдүүлэх, багийг идэвхижүүлж тэднийг зорилгод чиглүүлэн төлөвлөх зэрэг удирдлагын арга барилуудаас кейс, дасгал ажлуудад үндэслэн, харьцуулсан анализ хийж, туршилтаар дэлгэрүүлэн сургалтыг үр дүнтэйгээр зааж сургасан танай баг хамт олонд баярлалаа.



Чиглэл ХХК-ийн удирдлагын багаас



Зэ Цэ Фэйшн ХХК-ийн захирал

Б.Болормаа

Анх 2023 оноос BPN-тэй холбогдсон. Сургалтуудад суух бүртээ мэдэхгүйгээ мэдэж өөрийгөө хөгжүүлэхийн зэрэгцээ, орчин үеийн бизнесийн мэдээ мэдээлэл, илүү дэвшилтэт түвшний ажлын арга барил, чадваруудын тухай ойлголтыг авдаг. Мөн бусад бизнес эрхлэгчдийн туршлага, харах өнцгийг ойлгож өөрийн бизнесийн талаарх баримжааг олж харсан. Цаашид хамтран ажиллаж мэргэжлийн бизнес эрхлэгч болж хөгжихийг хүсэж байна. BPN-ийн хамт олондоо ажлын өндөр амжилт хүсье.



БАЯРЛАГАА



Сургалтын хуваарь



Маркетинг

2025.01.30 - 31

Санхүүгийн хөрвөх чадварын төлөвлөгөө

2025.02.13

Санхүүгийн менежмент

2025.03.13 - 14

Contract Readiness
Export Readiness

2025.03.25 - 26

Fundraising

2025.04.29

Зөрчлийн менежмент

2025.05.15 - 16

Цагийн менежмент

2025.06.24

Хамт олноо удирдах

2025.10.09 - 10

Хэлцэл болон борлуулалтыг амжилттай хийх нь

2025.10.14

Бизнесийн удирдлага

2025.12.04 - 06

